

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ  
ИНСТИТУТИЙН ЗАХИРЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТБААТАР  
ТАНАА

2021.02.25 № 07/508  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

001050982

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	32,329,163.00	36,508,345.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
31210	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	32,329,163.00	36,508,345.00
35400	Хангамжийн материал	32,329,163.00	36,508,345.00
35410	Бичиг хэргийн материал	11,418,992.00	10,931,842.00
35420	Аж ахуйн материал	84,000.00	6,539,875.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,298,500.00	5,343,200.00
35440	Түлш, шатах тослох материал	2,868,000.00	2,056,000.00
35490	Бусад хангамжийн материал	12,659,671.00	11,637,428.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	134,207,304.34	116,375,926.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	134,207,304.34	116,375,926.11
39200	Биет хөрөнгө	88,925,414.06	91,317,777.21
39203	Авто-тээврийн хэрэгсэл	163,377,700.00	163,377,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(162,252,700.00)	(163,377,700.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	237,878,479.27	267,266,299.27
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(213,006,703.91)	(224,817,752.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161,646,189.89	162,625,989.89
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(104,268,551.19)	(119,307,759.68)
39217	Номын фонд	5,551,000.00	5,551,000.00
39300	Биет бус хөрөнгө	45,281,890.28	25,058,148.90
39301	Програм хангамж	84,882,930.00	84,882,930.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(39,601,039.72)	(59,824,781.10)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	<b>166,536,467.34</b>	<b>152,884,271.11</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41300	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41311	Цалингийн өглөг	-	-
41312	НДШ-ийн өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	166,536,467.34	152,884,271.11
51	Засгийн газрын хувь оролцоо	166,536,467.34	152,884,271.11
51200	Хуримтлагдсан үр дүн	166,536,467.34	152,884,271.11
51210	Өмнөх үеийн үр дүн	218,354,578.42	166,536,467.34
51220	Тайлант үеийн үр дүн	(51,818,111.08)	(13,652,196.23)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>166,536,467.34</b>	<b>152,884,271.11</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх он	Тайлант он
31	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>667,174,951.00</b>	<b>775,673,656.00</b>
31200	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,999,531.00</b>	<b>30,367,620.00</b>
31210	Өмчийн орлого	11,999,531.00	30,367,620.00
31211	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,999,531.00	-
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,999,531.00	-
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	30,367,620.00
<b>1</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>655,175,420.00</b>	<b>745,306,036.00</b>
<b>13</b>	Улсын төсвөөс	586,349,100.00	722,003,300.00
1310	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	586,349,100.00	722,003,300.00
131001	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,826,320.00	23,302,736.00
1311	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,826,320.00	23,302,736.00
131105	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>718,993,062.08</b>	<b>789,325,852.23</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>718,993,062.08</b>	<b>789,325,852.23</b>
210	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>707,709,305.90</b>	<b>714,140,748.14</b>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	462,171,674.03	525,281,401.01
210101	Үндсэн цалин	400,821,158.03	508,866,712.01
210102	Нэмэгдэл	38,749,716.00	-
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	18,054,000.00	-
210105	Гэрээт ажлын цалин	4,546,800.00	16,414,689.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,352,756.99	67,176,314.88
210201	Тэтгэвэрийн даатгал	39,731,306.12	46,440,699.65
210202	Тэтгэмжийн даатгал	4,653,900.00	5,410,285.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,723,058.00	4,102,629.74
210204	Ажилгүйдлийн даатгал	930,799.59	995,752.86
210205	Эрүүл мэндийн даатгал	9,313,693.27	10,226,946.64
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>		
35400	Хангамжийн материал		
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал		
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
35490	Бусад хангамжийн материал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,506,540.00	2,577,691.00
2106	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	15,338,022.00
210601	Эд хогшил, урсгал засварын зардал	4,599,345.00	4,464,700.00
210604	Багаж, техник, хэрэгсэл	3,451,345.00	3,084,700.00
2107	Урсгал засвар	1,148,000.00	1,380,000.00
210702	Томиллолт, зочны зардал	10,642,000.00	3,372,500.00
210702	Дотоод албан томиллолт	10,642,000.00	3,372,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,840,285.00	7,080,765.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,651,720.00	-

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	547,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	262,565.00	266,765.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	110,000.00	190,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,804,989.08	48,909,151.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	406,177.00	575,153.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	12,594,939.00	135,000.00
	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,803,873.08	48,198,998.23
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,283,756.18</b>	<b>75,185,104.09</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,319,156.18	75,185,104.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,319,156.18	75,185,104.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,964,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,964,600.00	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(51,818,111.08)</b>	<b>(13,652,196.23)</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	-	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>(51,818,111.08)</b>	<b>(13,652,196.23)</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>655,175,420.00</b>	<b>745,306,036.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>655,175,420.00</b>	<b>745,306,036.00</b>
1310	Улсын төсвөөс	586,349,100.00	722,003,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	586,349,100.00	722,003,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	68,826,320.00	23,302,736.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,826,320.00	23,302,736.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>655,175,420.00</b>	<b>745,306,036.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>655,175,420.00</b>	<b>745,306,036.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>643,856,263.82</b>	<b>669,300,931.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>462,142,025.30</b>	<b>525,281,401.01</b>
210101	Үндсэн цалин	346,574,725.30	381,810,237.64
210102	Нэмэгдэл	74,581,300.00	92,681,313.32
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	36,036,000.00	34,375,161.05
210105	Гэрээт ажлын цалин	4,950,000.00	16,414,689.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,089,155.72</b>	<b>67,176,314.88</b>
210201	Тэтгэвэрийн даатгал	39,473,455.72	46,462,591.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,653,900.00	5,359,899.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,723,400.00	4,095,840.62
210204	Ажилгүйдлийн даатгал	930,800.00	999,034.78
210205	Эрүүл мэндийн даатгал	9,307,600.00	10,258,947.97
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>-</b>	<b>1,080,000.00</b>
210304	Байрны түрээс	-	1,080,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,550,997.80</b>	<b>58,219,528.02</b>
210401	Бичиг хэрэг	15,100,880.00	14,344,199.00
210402	Тээвэр, шатахуун	13,612,200.00	5,758,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,118,351.80	16,370,784.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	12,525,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,719,566.00	9,221,545.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,002,400.00	4,329,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,274,600.00	2,067,800.00
210604	Урсгал засвар	3,727,800.00	2,261,700.00
2107	Томиллолт, зочны зардал	10,642,000.00	3,727,470.00
210702	Дотоод албан томилолт	10,642,000.00	3,727,470.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44,840,285.00</b>	<b>7,080,765.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,651,720.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	6,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	547,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	262,565.00	266,765.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	110,000.00	190,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,589,400.00	2,405,953.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	997,800.00	1,502,953.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	12,591,600.00	903,000.00

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,319,156.18</b>	<b>76,005,104.09</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,319,156.18	75,185,104.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,319,156.18	75,185,104.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	820,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	820,000.00
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)</b>	-	-
14	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
15	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		-	<b>218,354,578.42</b>	<b>218,354,578.42</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-		-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
Тайлант үеийн үр дүн	-	-	(51,818,111.08)	(51,818,111.08)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		-	<b>166,536,467.34</b>	<b>166,536,467.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-		-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		-	<b>166,536,467.34</b>	<b>166,536,467.34</b>
Өмнөх үеийн үр дүн				
Тайлант үеийн үр дүн		-	(13,652,196.23)	(13,652,196.23)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>		-	<b>152,884,271.11</b>	<b>152,884,271.11</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр					
	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>722,003,300.00</b>	<b>646,818,195.91</b>	<b>75,185,104.09</b>	<b>89.6</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>721,183,300.00</b>	<b>645,998,195.91</b>	<b>75,185,104.09</b>	<b>89.6</b>
210	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>721.183.300.00</b>	<b>645,998,195.91</b>	<b>75,185,104.09</b>	<b>89.6</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,852,000.00	508,866,712.01	60,985,287.99	89.3
210101	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,824,100.00	66,308,137.88	13,515,962.12	83.1
210102	Тэтгэврийн даатгал	56,172,600.00	45,594,414.90	10,578,185.10	81.2
210103	Тэтгэмжийн даатгал	5,913,000.00	5,359,899.61	553,100.39	90.6
210105	ҮОМШӨ ний даатгал	4,730,300.00	4,095,840.62	634,459.38	86.6
2102	Ажилгүйдлийн даатгал	1,182,500.00	999,034.78	183,465.22	84.5
210201	Эрүүл мэндийн даатгал	11,825,700.00	10,258,947.97	1,566,752.03	86.7
210202	Хангамж, бараа материалын зардал	58,254,900.00	57,910,128.02	344,771.98	99.4
210203	Бичиг хэрэг	14,189,300.00	14,184,799.00	4,501.00	99.9
210204	Тээвэр (шатахуун)	5,767,000.00	5,758,000.00	9,200.00	99.9
2104	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	16,545,500.00	16,220,784.02	324,715.98	98.0
210401	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,525,000.00	12,525,000.00	-	100.0
210402	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	9,227,900.00	9,221,545.00	6,355.00	99.9
210403	Эд хогшил худалдан авах	4,420,800.00	4,329,500.00	91,300.00	97.9
210405	Багаж, техник хэрэгсэл	2,067,800.00	2,067,800.00		100.0
210406	Урсгал засвар	2,353,000.00	2,261,700.00	91,300.00	96.1
2108	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210801	Тээврийн хэрэгслийн татвар	267,000.00	266,765.00	235.00	99.9
210802	Тээврийн хэрэгслийн оношилгоо	78,200.00	77,000.00	1,200.00	98.5
210803	Даатгалын үйлчилгээ	547,700.00	547,000.00	700.00	99.9
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	190,000.00	190,000.00	-	100.0
210805	Бараа үйлчилгээний бусад зардал	1,748,600.00	1,502,953.00	245,647.00	85.9
2109	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>820,000.00</b>	<b>820,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210901	Бусад урсгал шилжүүлэг	820,000.00	820,000.00	-	100.0
210902	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	820,000.00	820,000.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>722,003,300.00</b>	<b>646,818,195.91</b>	<b>75,185,104.09</b>	<b>89.6</b>
	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>722,003,300.00</b>	<b>646,818,195.91</b>	<b>75,185,104.09</b>	<b>89.6</b>
	Улсын төсвөөс санхүүжих	722,003,300.00	646,818,195.91	75,185,104.09	89.6
	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>				
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				

	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-			-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-			-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-			-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>23,302,736.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>23,302,736.00</b>
210	Бараа, үйлчилгээний зардал		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,484,689.00
2101	Гэрээт ажлын хөлс		16,484,689.00
210101	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		868,177.00
210101	Тэтгэврийн даатгал		868,177.00
210406	Хангамж, бараа материалын зардал		309,400.00
210401	Бичиг хэрэг		159,400.00
2109	Байрны түрээс		1,080,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210403	Шуудан холбоо, интернетийн		150,000.00
2106	Урсгал засвар		
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		903,000.00
2107	Дотоод албан томилолт		3,727,470.00
213	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>23,302,736.00</b>
2133	Нэмэлт санхүүжилтийн орлого		23,302,736.00
213303	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Батбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 06-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Энич Аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар судалгаа, шинжилгээ хийх, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах
- Нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар судалгаа, шинжилгээ хийх, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах, хяналт үнэлгээ хийх
- Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны дотоод аудитын хяналт шалгалтаар өгөгдсөн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож,

Институтийн захирлын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 1/57 дугаар албан тоотой зөвлөмжийн хариуг хүргүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн дагуу орон тоондоо багтаан Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэнг Захирлын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн Б/10 дугаар тушаалаар томилон ажиллуулсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны эхний хагас жилийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 333,651.1 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 6,673.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанар болон орчин нөхцлийн хувьд материаллаг шинжтэй зүйл илрээгүй тул төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,652.2 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	32,329.2	36,508.4	4,179.2
Үндсэн хөрөнгө	134,207.3	116,375.9	(17,831.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>166,536.5</b>	<b>152,884.3</b>	<b>(13,652.2)</b>
Хуримтлагдсан үр дүн	166,536.5	152,884.3	(13,652.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>166,536.5</b>	<b>152,884.3</b>	<b>(13,652.2)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 36,508.0 мянган төгрөг болж 4,179.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 45,857.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 40,698.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан, 979.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын данс руу залруулах бичилт хийсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 116,375.9 мянган төгрөг болж 17,831.4 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын данснаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн залруулга 979.8 мянга, Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төслийн хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 29,387.8 мянга нийт 30,357.6



мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн, мөн тайлант хугацааны элэгдлийн зардал 48,198.9 мянган төгрөгийн зөрүүгээр буурсан үзүүлэлттэй холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үйл ажиллагааны орлого 108,498.7 мянган төгрөгөөр өссөн нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хүлээн авсан 18,368.1 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгэсэн, улсын төсвийн санхүүжилт өмнөх оноос 135,654.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилт 45,523.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 70,332.8 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 70,332.8 мянган төгрөгийн зардлаас нийгмийн даатгалд төлөх шимтгэл 71,933.2 мянган төгрөгөөр өсч, бараа үйлчилгээний зардал 34,209.1 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 35,759.5 мянга, урсгал шилжүүлэг 1,964.6 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 740,207.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 740,207.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба батлахдаа 18,203.7 мянган төгрөгөөр бууруулсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны 10 зорилтын хүрээнд 27 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 722,003.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 722,003.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 646,818.2 мянган төгрөгийг зарцуулж, 75,185.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 646,818.2 мянган төгрөг буюу 89.6 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 74,501.3 мянган, хангамж, бараа материалын зардлыг 344.8 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 91.3 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 2.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 245.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 74,501.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь 6 ажилтан хүүхдээ асрах чөлөөтэй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн 2 төсөл, хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээний үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор нийт 23,302.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 17,282.9 мянга, хангамж, бараа материалын зардалд 309.4 мянга, дотоод албан томилолтын зардалд 3,727.5 мянга, байрны түрээсийн зардалд 1,080.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 902.9 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны хуулийн дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тулган баталгаажуулахад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 109 мэдээлэл байршуулахаас 104 мэдээллийг хугацаанд нь байршуулан, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 1 гүйлгээг байршуулаагүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 979.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар илэрсэн 5,655.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өглөө.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Тайлант хугацаанд Шилэн дансны хуулийн дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тулган баталгаажуулахад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 109 мэдээлэл байршуулахаас 104 мэдээллийг хугацаанд нь байршуулан, 4 мэдээллийг хугацаа хоцроож, 5,655.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйл 6.1. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалттай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

#### **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн санхүүгийн тайлангийн явцад цаашид анхаарал татахуйц онцлог үйл явдалтай холбоотой дараах асуудал байлаа. Тухайлбал:**

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж буйтай холбоотой тухайн төсвийн шууд захирагчийн ажлын байранд ажиллах боломж хомс байснаас нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, анхан шатны баримтуудын бүрдлийг хянах, хөрөнгийн биет тооллого хийх, тайлбар тодруулга авах, тодорхойлсон эрсдэлтэй асуудлыг шийдвэрлэх зэрэгт аудитын цар хүрээ хязгаарлагдмал байсан болно.

Иймд дараагийн аудитаар дээрхи асуудлуудад анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2020</b>	Аудитын нэр:	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
			САГ-2021/112/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт</b>	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны хуулийн дагуу www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тулган баталгаажуулахад нийт 109 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 104, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, 1 мэдээллийг байршуулаагүй байна.	5,655.0	Албан шаардлага өгөх	Захирал, Ахлах нягтлан бодогч	Б.Батбаатар, Б.Пүрэвцэцэг
	<b>ДҮН</b>	<b>5,655.0</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 62/АО/70065  
САГ- 2021/112/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 109 мэдээлэл байршуулахаас 104 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр мэдээлэхээс 5,655.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулан биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн захирлын албан үүргийг орлон гүйцэтгэгч Б.Батбаатар, ахлах нягтлан бодогч Б.Пүрэвцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.БАТ-ЭРДЭНЭ

Д.УРТНАСАН





